



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/457

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант суманд “Дэвшил ундарга” хоршооны хийж гүйцэтгэсэн төв талбайн цэцгийн мандлын цэцэгжүүлэлт ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Д.Эрдэнэбат (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Г.Гончигсүрэн (Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны дарга)

Д.Пүрэвдорж (Хот тохижуулах газрын дарга)

Д.Золбаяр (Хот тохижуулах газрын дендрологич)

Нарийн бичгийн

дарга: Э.Оюунтунгалаг (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Тухайн ажлыг гэрээний дагуу шалгаж, үр дүнтэй хийгдсэн эсэхийг гүйцэтгэлээр шалгаж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Х.БАТБОЛД



8400001 1114

Zah A/457 Kb